

ТӨСЛИЙН ХУРААНГУЙ

Төслийн нэр:	МАК
Улс:	Монгол
Төслийн дугаар:	37729
Бизнесийн салбар:	Байгалийн нөөц
Төрийн/Хувийн:	Хувийн хэвшил
Байгаль орчны категори:	В
Захирлуудын Зөвлөлийн огноо:	2007 оны 11-р сарын 6-ны өдөр
Статус:	Бүтцийн Хэлэлцүүлэг хийгдсэн, Эцсийн Хэлэлцүүлэг хүлээгдэж буй
Төслийн хураангуй нийтлэгдсэн огноо:	2007 оны 9-р сарын 6-ны өдөр
Төслийн хураангуй шинэчилсэн огноо:	

Төсөл ба Төслийн хүрээнд Компани дараахи зүйлүүдийг хэрэгжүүлэх боломжтой болно:

түүний зорилтууд:

(a) Уул уурхайн салбарын орчин үеийн шаардлага хангасан Удирдлагын Мэдээлэлийн Системийг нэвтрүүлэх,

(b) Дахин санхүүжилт хийх,

(c) Элдэвийн уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэх болон сайн чанарын (утаагүй) харьцангуй цэвэр нүүрсийг үйлдвэрлэх.

Шилжилтийн үйл явцад

үзүүлэх нөлөөлөл:

Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих

Банк уг төслийн санхүүжилтээр дамжуулан МАК-ийг дунд хугацаанд өөрийн үйл ажиллагааг төлөвлөх хийгээд Монголын зах зээл дээр амжилттай өрсөлдөх чадвар бүхий дотоодын компани болоход нь дэмжлэг үзүүлнэ.

Ил тод байдал, бизнесийн болон байгаль орчны үйл ажиллагааны стандартуудыг тогтоох

Төсөл дараахи чиглэлүүдээр Компани болон уул уурхайн салбарын үйл ажиллагааны стандартуудыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна:

(a) Компаний байгаль орчны болон орон нутгийн нийгмийн хөгжлийн удирдлагын практикийг сайжруулна. Тухайлбал, Монголын уул уурхайн компаниудын дундаас анх удаа ашиглалтын дараа уурхайг хааж битүүмжлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, Байгаль Орчин болон Нийгмийн Хөгжлийн Төлөвлөгөө (БОНХТ) боловсруулж мөрдөх;

(b) Салбарын тэргүүний практик бүхий Удирдлагын Мэдээлэлийн Системийг (УМС) Компанид нэвтрүүлэх, УМС нь уул уурхайн салбарын стандарт болсон 'MicroMine' болон 'Surpac' дээр үндэслэсэн байх болно;

(c) Утаагүй нүүрс боловсруулах үйлдвэр байгуулах олон улсын жишигт нийцсэн техник эдийн засгийн үндэслэлийг дотоодын уул уурхайн компани анх удаа бэлтгэснээр Монголын улсын дотоодын

төсөл бэлтгэх стандартыг дээшлүүлэх болно

(d) Төслийн хүрээнд анх удаа Монголын дотоодын уул уурхайн компани Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын шаардлагуудыг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Харилцагч:

Монголын Алт Корпораци ('МАК' буюу 'Компани'), Монголын нүүрс олборлогч дунд хэмжээний уул уурхайн компани.

ЕСБХБ-ны санхүүжилт:

30 сая америк долларын зээл

Төслийн нийт өртөг:

30 сая америк доллар

Байгаль орчинд

үзүүлэх нөлөөлөл:

Төслийг В/1 зэрэглэлийн дагуу шалгасан болно. Элдэвийн нүүрсний ордыг ил уурхайн хэлбэрээр ашиглаж байгаа тул бусад төрлийн уурхайн (тухайлбал, гүний) үйл ажиллагаанд гардаг байгаль орчны, эрүүл ахуйн, аюулгүй байдлын асуудлууд хамаарал багатай болно. Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлийн 1-р Шатны үнэлгээг олон улсын хөндлөнгийн мэргэжилтэн газар дээр нь очиж хийж гүйцэтгэсэн бөгөөд мөн Банкны байгаль орчны мэргэжилтэн давхар оролцсон болно. Үнэлгээгээр Элдэвийн уурхайн үйл ажиллагаанд Компаний БОНХТ-нд тусгаж сайжруулах шаардлагатай байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдалтай холбоотой цөөн асуудлууд байгааг тогтоосон ба бүхэлдээ уурхайн ашиглалт Монгол Улсын хууль, зохицуулалтын дагуу хэвийн явж байна гэж дүгнэсэн. Тэдгээр сайжруулбал зохих асуудлууд нь бүгд Компаний БОНХТ-д тусгагдах бөгөөд БОНХТ нь уг төслийн Зээлийн Гэрээний бүрэлдэхүүн хэсэг байх болно. БОНХТ-нд тусгагдах асуудлуудад үйлдвэрлэлийн болон ажилчдын аюулгүй байдлын эрсдлийг бууруулахын тулд хөрс хуулалтын эргийн налууны тогтвортой байдалд геотехникийн үнэлгээ хийх, хаягдлын аж ахуйн удирдлага болон тоосжилтыг бууруулах төлөвлөгөө боловсруулах болон ашиглалтын дараа уурхайг хааж битүүмжлэх төлөвлөгөө боловсруулах (Монголын дотоодын компани анх удаа ийм төлөвлөгөө боловсруулж буй тохиолдол) зэргийг оруулах болно.

Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хамгийн ихээр нэмэгдүүлж байгаа нэг хүчин зүйл бол хотын дулааны цахилгаан станцууд болон гэр хорооллын 134,000 өрх нүүрс хэрэглэж буй явдал юм. Агаарын бохирдлын түвшин өндөр байгаа нь хотын хүн амын эрүүл мэндэд үлэмж хэмжээний сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд амьсгалын замын өвчин, архаг бронхит, сүрьеэ болон бусад уушигны өвчлөл, тухайлбал хүүхдийн дунд, эрс нэмэгдэж байгаагийн гол шалтгаан болж байна. Банкны санхүүжилтийн нэг хэсэг нь Элдэвийн нүүрсний уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэх болон сайн чанарын (утаагүй) харьцангуй цэвэр нүүрсийг үйлдвэрлэхэд зарцуулагдах болно. Энэ утгаараа уг төсөл нь хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд цэвэр нүүрсний технологийг хөгжүүлэх болон техник, эрх зүйн арга хэмжээнүүдийг боловсруулах чиглэлээр ажиллаж буй Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банкны байгаль орчны мэргэжилтнүүдийн үйл ажиллагаагаар дэмжигдэх болно.

Техникийн

хамтын ажиллагаа:

Төслийг бэлтгэх болон Хөндлөнгийн Уул Уурхайн Инженерийн зөвлөгөөг авахад Банк өөрийн Монголтой Хамтран Ажиллах Сангаар дамжуулан 90,000 америк долларыг санхүүжилтийг хийж байгаа бөгөөд уг Техникийн Хамтын Ажиллагааны туслалцаа нь олон улсын жишигт нийцсэн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Компанид боловсруулж

өгөхөд зориулагдсан болно.

Техникийн хамтын ажиллагааны сангаас санхүүжигдэх хөндлөнгийн зөвлөхийн ажил үйлчилгээг худалдах авах талаар мэдээлэлийг [procurement of consultants](#) –ээс үзнэ үү.

Компанитай

МАК
14-р байр, XIII хороолол
Баянзүрх дүүрэг
Шуудангийн хайрцаг 237
Улаанбаатар 210349
Монгол Улс

холбоо барих:

ЕСБХБ-тай холбоо барих:

Энрико Грасси, Төслийн Удирдагч

Электрон шуудан grassie@ebrd.com

Бизнес хамтын ажиллагаа:

Бизнес хамтын ажиллагааны боломжийн талаар харилцагч компанитай холбоо барина уу.

Ерөнхий лавлагаа:

ЕСБХБ-наас төсөлтэй холбоотой лавлагаа (ажил үйлчилгээ худалдаж авахтай холбоогүй):
Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380
Электрон шуудан: projectenquiries@ebrd.com